

ЦУ № 01(06)

Цаг уур, агаарын бохирдол

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2010 оны 1 дүгээр сард хамгийн их тунадас (26.9 мм) Ховд аймгийн Булган суманд орсон байна. Энэ сард агаарын хамгийн их температур Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 9.4 хэм дулаан, хамгийн бага температур Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Завхан аймгийн Тэс суманд -47.0 хэм хүйтэн, цасан бүрхүүлийн хамгийн их зузаан Завхан аймгийн Баянхайрхан суманд 77 см байжээ. Салхины хамгийн их хурд Говь-Алтай аймгийн Бугат суманд 40 м/сек хүрсэн байна.

Олон жилийн дундажтай харьцуулбал Өлгий, Ховд хотуудаас бусад хот, нийслэлд энэ оны 1 дүгээр сард 0.1-ээс 4.7 хэмээр хүйтэн байсан байна.


Азотын давхар ислийн агууламж 2010 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг орчимд 2 удаа, Баруун дөрвөн зам орчимд 6 удаа, 1-р хороолол орчимд 18 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, 32-ын тойрог орчимд 16 удаа, Офицеруудын ордон орчимд 11 удаа, хүхэрлэг хийн агууламж Хан-Уул дүүрэг орчимд 27 удаа, 1-р хороолол орчимд 22 удаа, 13-р хороолол орчимд 30 удаа, 32-ын тойрог орчимд 21 удаа, Офицеруудын ордон орчимд 28 удаа, 10 микроон хүртэлх тоосны агууламж Хан-Уул дүүрэг орчимд 4 удаа, 1-р хороолол орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 30 удаа, Дархан-Уул аймгийн Дархан суманд 19 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс тус тус давсан байна.

Аюулт үзэгдэл, осол


Аюулт үзэгдэл, осол 2010 оны 1 дүгээр сард 274 удаа гарсны улмаас 33 хүн амь насаа алдаж, 1.8 сая толгой мал хорогджээ. Аюулт үзэгдэл, ослыг төрлөөр нь авч үзвэл хүчтэй цасан болон шороон шуурга 4 удаа, газар хөдлөлт 2 удаа гарчээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 476.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо 49 тохиолдол буюу 21.8 хувь, амь насаа алдсан хүний тоо 22 буюу 3.0 дахин, хорогдсон малын тоо 1.7 сая толгойгоор нэмэгдсэн байна.

Зураг 1.



Зураг 2.



Хүснэгт 1.

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар*

Үзүүлэлт	2008	2009	2010	2010 2009 %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	238	225	274	121.8
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүн	34	11	33	300.0
Шатсан гэр, орон сууцны тоо	81	57	154	270.2
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, амьтан, мян.тол	1.7	0.5	1.8**	3118.9 ***
Объектын түймрийн тоо	224	216	260	120.4

Тайлбар: *-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ

** -Сая толгой

*** -Дахин их